



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/552

Арвайхээр сум

Цэргийн албыг 2023-2025 онд биеэр дүйцүүлэн
хаах иргэдийн "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл
сургалт"-ыг зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 30.3, дахь заалт, Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг 2023-2025 онд биеэр дүйцүүлэн хаалгахаар сумдаас ирүүлсэн саналын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл"-шатны сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 45 иргэний тоог 1 дүгээр, "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл"-шатны сургалтад шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт явуулахад шаардагдах 13,532,500 (арван гурван сая таван зуун гучин хоёр мянга таван зуу) төгрөгийн 6,766.250 (зургаан сая долоон жаран зургаа мянга хоёр зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 6,766,250 (зургаан сая долоон жаран зургаа мянга хоёр зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

4."Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл"-шатны сургалтад оролцох цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын үүрэг гүйцэтгүүлэх бэлэн байдал, хувийн бэлтгэлийг хангуулж, тогтоосон хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа М.Нямхүү)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 1105

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06 ны өдрийн 415 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



2023 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоо

д/д	Сумын нэр	Хүний тоо
1	Арвайхээр сум	4
2	Хархорин сум	3
3	Сант сум	2
4	Өлзийт сум	2
5	Баян-Өндөр сум	2
6	Бүрд сум	2
7	Баянгол сум	2
8	Зүүнбаян-Улаан сум	2
9	Баруунбаян-Улаан сум	2
10	Богд сум	3
11	Есөнзүйл сум	2
12	Нарийнтээл сум	2
13	Уянга сум	3
14	Төгрөг сум	2
15	Тарагт сум	2
16	Хайрхандулаан сум	2
17	Бат-Өлзий сум	3
18	Гучин –Ус сум	2
19	Хужирт сум	3
Нийт дүн		45

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1509 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ”-ЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Хоолны зардал /Цэрэг нормоор/	45 хүн	15.000 төгрөг (өдөрт 4 удаа, 14 хоног)	9,450,000 төг
2	Замын зардал	45 хүн	100000 төг (4x25.000) 40000 төг (2x20.000) 121100 төг (7x17.300) 240000 төг (16x15.000) 32000 төг (2x16.000) 48000 төг (4x12.000) 40000 төг (4x10.000)	621,100 төгрөг
3	Хичээлийн хэрэглэл - бал - дэвтэр -принтерийн хор -бичгийн цаас -бусад бичиг хэргийн хэрэгсэл -дурсгалын зураг, батламж хэвлүүлэх	45 ш 45 ш 1ком 2 боодол - 45 ш	27000 төг (45x600) 45000 төг (45x1000) 80.000 төг 36.000 төг 50.000 төг 270000 төг (45x6000)	508,000 төгрөг
4	ШТМ, цахилгааны зардал	- ДТ - АИ-92 -Цахилгааны зардал	180*3660 100*2470 -	658.800 төгрөг 247.000 төгрөг 180.600 төгрөг (903 кВт) Нийт: 1.086.400 төгрөг
5	Бусад зардал	- Аймгийн төвд явагдах сургалтад портер машин 1 нэгж гарна. ШТМ ДТ-80л, Масло, Портер машины түрээс - Түлээ 40 шуудай мод, - Ундны ус -. Жагсаалын дарга (1), тогооч (1) цалин - Халуун усанд оруулах	80x3660=292.000 5л*13000=65.000 10x25000=250.000 40x6000=240.000 (1тн-5000)- 14тн*5000=70.000 250.000*2=500.000 1 хүнийг 2 удаа оруулахад 10000*45=450.000	1,867,000 төгрөг
Дүн		13,532,500 төгрөг		